



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2010 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/294

Булган

Хүүхдийн баяр зохион байгуулах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.1, 16.4.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.6 дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд баярын нээлтийн арга хэмжээг Цогт хун тайжийн талбайд зохион байгуулсугай.
2. Нээлтийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зохион байгуулах ерөнхий удирдамжийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 6120000 /зургаан сая нэг зуун хорин мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс хавсралтын дагуу гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.
4. Нээлтийн арга хэмжээг амжилттай зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, аймгийн Засаг даргын орлогч /Ц.Бат-Өлзий/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

109
Аймгийн Засаг даргын 2018 оны 45 дугаар сарын...
өдрийн 12/24 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

**ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий

Гишүүд: АЗДТГ-ын НБХ-ийн дарга Э.Түвшинмөнх
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Т.Баярбат
Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн О.Ууганчимэг
Хөгжимт жүжгийн театрын дарга Т.Бэхтөр
Булган сумын 1-р 12 жилийн сургуулийн захирал Д.Зоосүрэн
Булган сумын 1-р 12 жилийн ЭӨЦ сургуулийн захирал Н.Янжмаа
Булган сумын 3-р 12 жилийн сургуулийн захирал Л.Гэрэлтуяа

Нарийн бичгийн дарга: АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн М.Батчимэг

190

Аймгийн Засаг даргын 2018 оны 06 дугаар сарын 15
өдрийн 1594 тоот захирамжийн хоёрдугаар хавсралт

**ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН УДИРДАМЖ**

Зорилго:

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр олон нийтийн санал санаачлагыг өрнүүлэн, “Булган аймаг байгуулагдсны түүхт 80 жилийн ой”-н арга хэмжээний хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхэд үйл ажиллагааны зорилго оршино.

Хамрах хүрээ, хугацаа:

Булган сумын нийт хүүхэд багачуудыг хамруулан 2018 оны 06 сарын 01-ний өдрийн 11:00-17:00 цагийн хооронд “Цогт Хун Тайжийн талбай”, “Хүүхэд залуучуудын соёл, амралтын хүрээлэн”, аймгийн ХЖТ-т тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдана.

Зохион байгуулагчид:

- АЗДТГ Нийгмийн бодлогын хэлтэс
- Булган сумын ЗДТГ
- Гэр бүл , хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,
- Хөгжимт жүжгийн театр
- Хүүхдийн төлөө гишүүн байгууллагууд

Дөрөв. Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:

1. Нээлтийн үйл ажиллагаа /“Цогт Хун Тайжийн талбай”-д /
 - Хүүхдийн парад /Төрийн банкнаас-Төв талбай руу алхах/
 - 800 хүүхдийн бат илэрхийлэл /Булган аймгийн түүхт 80 жилийн ойн хүрээнд/
 - Урлагийн тоглолт /Булган хангайн хүүхдүүд урлагийн наадмын гала тоглолтоос/
 - Алдарт эхийн одон гардуулах ёслолын арга хэмжээ
 - Аймгийн “Шилдэг хүүхдүүд”-д шагнал гардуулах
 - Үлгэрийн баатрууд болон хүүхэд багачуудын үзэх дуртай хүүхэлдэйн киноны баатруудын багт жагсаал /хүүхдүүдтэй зураг авахуулах/
 - 800 хүүхдийн найрал дуу, үг бүтээх /Булган аймгийн газрын зураг, 80 тоо/
2. Оролцогч хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг өгөх
3. Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнд тусгай хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулагдах /12:00-17:00 Булган сумын ЗДТГ/
4. Хүүхдийн жүжиг / 17:00 аймгийн ХЖТ /

ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

141
Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 15
өдрийн 1/2024 тоот захирамжийн гуравдугаар хавсралт

**ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ**

№	Шаардагдах төсөв	Хэмжих нэгж, тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт
1.	Хүүхдийн бэлэг	800 ш	7000	5600000
2.	Тайз чимэглэх болон хүүхдүүдийн гарт бариулах шаар	2000 ш	200	400000
3.	Тайзны арын хулдаасан хэвлэл /4*5 м/	1 ш	6000	120000
4.	Дүн			6120000